



**ДАРХАН - ХОТ БАЙГУУЛАЛТ,  
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР  
ОНӨААТҮГазрын ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/60

Дархан

Г Ёс зүйн дүрэм батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.10 дахь заалт, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зэрчлээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг байгууллагын ёс зүйн дэд хороонд даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн A/01-1 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.



**452510090**

D/BZ-2025-Tushaal

Дархан-Хот байгуулалт барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ЫН Даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тушаалтын хавсралт

“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАЧ” ОНӨААТҮГ-ЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ЫН ажилтны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2.Байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүй нь нийгмийн талаарх нэг талыг бариагүй, өргөн хүрээтэй, дэлгэрэнгүй, мэдээлэгчийн эрхийг хүндэтгэсэн, нууцлал, аюулгүй байдал нь хангагдсан мэдээллээр бүх гүйцэтгэгчдэд адил тэгш үйлчлэх явдал юм.

1.3.“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ЫН ажилтан бүр Монгол Улсын Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг биелүүлж, ёс зүйг баримтлахын зэрэгцээ дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

2.1.“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ЫН үнэт зүйлс нь мэргэжлийн ур чадвар, үнэн бодит байдал, нэгдмэл байдал, мэдээллийн нууцлалыг хангах юм.

2.1.1.Шударга, зарчимч байх-Ажил үүргээ гүйцэтгэхдээ зөвийг эрхэмлэн дээдэлж, байгууллагын эрх ашгийг ямагт тэргүүнд тавьж, шударга бус байдалтай үл эвлэрэн, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх.

2.1.2.Хараат бус байж, гадны нөлөөнд үл автах-Зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд албан үүргээ биелүүлэн аливаа гадны нөлөөллөөс ангид байх.

2.1.3.Төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалах - Албан үүргийн хүрээнд өөрийн ажлын шугамаар олж авсан төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээ, мэдээллийг чанд хадгалж, аливаа хэлбэрээр бусдад мэдээлэхгүй байх.

2.1.4.Захирах, захирагдах ёсыг баримтлах - төрийн албаны тухай хуульд заасан зарчмыг баримталж удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг дурдсан хугацаанд бүрэн биелүүлэх.

2.1.5.Хариуцлагатай байх-Тухайн ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж, ажил үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлбэл зохих хугацаанд нь гүйцэтгэхийн төлөө авч хэрэгжүүлбэл зохих бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэн чанарын шаардлага хангасан гүйцэтгэл, үр дунд хүрдэг, хүрэхийн төлөө өөрийгөө бүх талаар дайчлан ажиллаж, өөртөө болон бусдад зарчимч шаардлага тавьж, хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх, ажил мэргэжилдээ болон хамт олондоо хүндэтгэлтэй хандах.

2.1.6.Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх - Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай

хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах тухай хуульд заасан зарчмыг баримталж ажиллах;

## ГУРАВ. ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

3.1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгуулах, чөлөөлөх.

3.1.1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн 3-аас доошгүй, сондгой тоо бүхий гишүүнтэй байх бөгөөд сонгогдсон гишүүд газрын даргын тушаалаар баталгаажна.

3.2. Ёс зүйн дэд хороо нь дараах эрх, үүрэгтэй ажиллана.

3.2.1. Байгууллагын ажилтны баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах.

3.2.2. “Хүний эрх хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх гомдол мэдээлэл”-ийг ёс зүйн зөрчлийн нэгэн адил тооцон хүлээн авч ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрлэх, гомдол, мэдээлэл гаргагчид хариу өгөх ба гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээг холбогдох байгууллагад уламжлах эрхтэй.

3.2.3. Гомдол, мэдээллийг хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргах бөгөөд энэхүү дүгнэлт нь аливаа албан тушаалтан, улс төрийн хүчиний нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байх.

3.2.4. Ёс зүйн дэд хорооны хуралдаанд өргөдөл, гомдол гаргагчаас бичгээр болон амаар шаардлагатай гэж үзвэл тайлбар авна.

3.2.5. Ёс зүйн дэд хороо тухайн ёс зүйн зөрчлийг хуралдаанаараа хэлэлцээд олонхийн саналаардүгнэлт гаргана. Ёс зүйн дэд хорооны хуралдааны шийдвэр нь дүгнэлтийг гишүүд болон нарийн бичгийн дарга, дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.2.6. Ёс зүйн дэд хороо нь ёс зүйн зөрчлийг хуралдаанаараа хэлэлцээд дараах байдлаардүгнэлт гаргана.

- ✓ Ёс зүйн зөрчилгүй хэмээн буцаах.
- ✓ Ёс зүйн зөрчил гаргасан нотолгоо, баримт бичгийн бүрдэл шалгах.
- ✓ Зөрчлийн шинж байдал, дахин давтагдсан байдлыг харгалзан тус хуралдааны протокоор сануулах.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулах саналыг Газрын даргад хүргүүлэх.

3.2.7. Ёс зүйн дэд хороо нь улирлын ажлын тайланг Дархан-Уул аймгийн Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.

3.2.8. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд улирал бүр урамшуулал олгох асуудлыг газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

## ДӨРӨВ. МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаа “Дархан хот байгуулалт, барилга захиалгчийн газар” ОНӨААТҮГ-ын ажилтныг шагнаж урамшуулах, дэвшүүлэн томилох, ур чадвар олгох, үр дүнгийн урамшуулал, шагналт цалин олгох, зөрчил гаргавал сахилгын арга хэмжээ авах, ажлаас чөлөөлөх үүрэгтэй.

—оOо—